

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

**МОНГОЛ, АФГАНИСТАНЫ ХАРИЛЦААНЫ
ШИНЭ ҮЕ ШАТ****М. Хурметхан.**

МАХН, БНМАУ-ын засгийн газрын гадаад бодлогын нэг чухал чиглэл бол улс түмний үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнол, нийгмийн хөгжил дэвшлийн төлөө тэмцлийг бүх талаар дэмжих явдал байдаг. Чухам энэ зарчмын үүднээс БНМАУ социалист чиг баримжааны орнуудтай найрамдал, эв санааны нэгдлийн харилцааг амжилттай хөгжүүлж байна. Үүний яруу тод үлгэр жишээ нь БНМАУ БНААфГУ-ын хоорондын найрамдал, пролетарийн интернационализм, хувьсгалт эв санааны нэгдлийн зарчимд тулгуурласан харилцаа болно.

Афганистаны Ардын Ардчилсан Намын (ААН) удирдлагаар Афганистанд ялсан Дөрөвдүгээр сарын хувьсгалын ялалтын үрээр манай хоёр орны хооронд найрамдал, хамтын ажиллагааны зарчмын шинэ агууллагад тулгуурласан харилцаа хөгжих боломж нээгдсэн юм. Дөрөвдүгээр сарын хувьсгалын үр дүнд байгуулагдсан БНААфГУ-ын засгийн газрыг анх хүлээн зөвшөөрсөн улсуудын нэг нь БНМАУ байв. Манай улс БНААфГУ-ын хувьсгалт засгийн газартай даян дэлхийн энх тайван, ардчилал, нийгмийн дэвшлийн эрх ашгийн үндсэн дээр Монгол-Афганистаны харилцааг хөгжүүлэхэд өөрийн талаас бэлэн байгааг мэдэгдсэн билээ.

БНМАУ-ын сайн санааны санаачлагыг БНААфГУ талархан угтсан тэр үеэс хоёр орны хооронд пролетарийн интернационализмын зарчимд үндэслэгдсэн шинэ харилцаа бий болж, ялангуяа Дөрөвдүгээр сарын хувьсгалын хоёрдугаар шатны дараа энэ харилцаа нь шинэ агуулга, хэлбэрээр баяжин өргөжсөн юм.

БНМАУ, БНААфГУ-ын хоорондын найрамдал, хамтын ажиллагаа өнгөрсөн хугацаанд олон салбарт амжилттай хөгжиж ирэв. Монгол, Афганистаны хооронд нам, төрийн шугамаар төлөөлөгчид харилцан айлчлах, шинжлэх ухаан, соёл, урлаг, спортын салбарт эрдэмтэн, жүжигчид, тамирчид солилцох, үзэсгэлэн, кино үзлэг харилцан зохион байгуулах зэрэг адил зохиогдсон нь манай хоёр ард түмэн бие биеэ харилцан ойлгох, нэг нэгнийхээ туршлагаас суралцахад сайхан боломж олгосон юм.

Өнгөрсөн таван жилд МАХН, БНМАУ-ын засгийн газар Афганистаны нам, засгийн газраас явуулж байгаа гадаад, дотоод дэвшилт бодлогыг цаг тухайд нь олон хэлбэрээр дэмжин, энх тайван, улс түмний найрамдал, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгдсэн өнөө үеийн олон улсын зангилаа асуудлаар БНААфГУ-тай идэвхтэй хамтран ажиллаж ирэв. Энэ бүхэн нь манай хоёр орны ах дүүгийн харилцаа цаашид улам гүнзгийрэн хөгжих бат бэх суурь тавигдсаныг харуулж байгаа юм.

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгч-

дийн урилгаар АААН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНААфГУ-ын Хувьсгалт Зөвлөлийн дарга нөхөр Бабрак Кармаль тэргүүтэй БНААфГУ-ын нам, төрийн төлөөлөгчдийн 1983 оны 7-р сарын 8—13-нд манай оронд хийсэн албан ёсны найрсаг айлчлал нь Монгол, Афганистаны харилцааны цаашдын хөгжилд онцгой чухал ач холбогдолтой түүхэн үйл явдал болов. Уг айлчлалын үеэр Афганистаны нам засгийн төлөөлөгчид, манай нам, төрийн удирдагчидтай уулзан гэрээ хэлэлцээ хийж ихээхэн ач холбогдол бүхий хоёр улсын хоорондын анхны баримт бичгүүдэд гарын үсэг зурсан билээ. Мөн айлчлалын явцад БНМАУ, БНААфГУ-ын хооронд Найрамдал, хамтын ажиллагааны тухай Гэрээ байгуулагдсан нь МАХН, АААН болон БНМАУ, БНААфГУ-ын хоорондын харилцааг шинэ шатанд гарган хоёр ард түмний ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэх хэтийн сайхан төлөв нээж өглөө.

БНМАУ, БНААфГУ-ын хооронд байгуулагдсан найрамдал хамтын ажиллагааны тухай Гэрээ нь манай хоёр орны ард түмний харилцааны түүхэнд онцгой чухал тэмдэглэлт үйл явдал болов. Улаанбаатар хотод болсон Монгол, Афганистаны найрамдлын цуглаан дээр МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю. Цэдэнбал хэлсэн үгэндээ хоёр орны хооронд байгуулагдсан Найрамдал, хамтын ажиллагааны тухай Гэрээний ач холбогдлыг үнэлэн «Найрамдал, хамтын ажиллагааны тухай Гэрээ нь БНМАУ, БНААфГУ-ын хоорондын харилцааны шинэ үе шатыг нээж байна. Энэ Гэрээ улс түмний энх тайван харилцан ойлгох, хамтран ажиллах үйлсэд үйлчлэх болно»¹ хэмээн тэмдэглэсэн юм. Ах дүүгийн найрамдал, бүх талын хамтын ажиллагаа тэгш эрх, харилцан ашигтай байх, үндэсний бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох дээд зарчмуудыг бүрэн тусгасан энэ Гэрээ нь БНМАУ, БНААфГУ-ын хоорондын шинэ харилцааг хуульчилан бататгаж өгсөн түүхэн ач холбогдолтой баримт бичиг боллоо.

МАХН, АААН болон БНМАУ, БНААфГУ-ын найрамдал, хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд Найрамдал, хамтын ажиллагааны гэрээ нэн чухал үүрэг гүйцэтгэх юм. Үүнд: Гэрээнд хоёр улсын хоорондын худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэн дээрхи салбаруудаар хоёр талын холбогдох байгууллагуудын хооронд гэрээ хэлэлцээр байгуулахаар заажээ. Түүнчлэн Гэрээнд хоёр орны хооронд шинжлэх ухаан, соёл, урлаг, утга зохиол, боловсрол, эрүүлийг хамгаалах, хэвлэл, радио, кино, жуулчлал, спортын болон бусад салбарт хамтран ажиллах, туршлага солилцох явдлыг хөгжүүлэх явдалд тус дөхөм үзүүлнэ гэжээ. Хоёр орны хоорондын харилцааг улам өргөжүүлж, гүнзгийрүүлэн батжуулахад уг гэрээ бүрэн чиглэгдэж байна. Ингэснээрээ түүхийн уламжлалт харилцаатай байсан манай ард түмнүүдийн харилцаа түүхийн шинэ нөхцөлд шинэ агуулга зарчимд үндэслэгдэн хоёр ард түмний тусын тулд улам гүнзгийрэн хөгжих болно.

БНМАУ, БНААфГУ-ын хоорондын найрамдал хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхэд харилцан бие биеийн туршлагаас суралцах нь маш чухал юм. ЗХУ тэргүүтэй ах дүү социалист хамтын нөхөрлөлийн орнуудын туршлага, эв санааны нэгдэл нь шинэ нийгэм байгуулж байгаа БНААфГУ-д онцгой чухал ач холбогдолтойг тэмдэглэн нөхөр Бабрак Кармаль хэлэхдээ «Энэхүү эв санааны нэгдлийг зөвхөн цэрэг эдийн засгийн тусламж гэж үзэж болохгүй. Шинэ амьдрал цогцлон

байгуулахад манай анд нөхдийн үзүүлж байгаа үлгэр жишээний хүч, тэдний хуримтлуулсан үнэт туршлага, цагаа олсон мэргэн зөвлөлгөө бидний хувьд амин чухал ач холбогдолтой юм»² гэсэн билээ. БНААфГУ-ын эрхэм дээд зочид БНМАУ-д айлчлахдаа МАХН-ын удирдлагаар монголын ард түмэн социализм байгуулж байгаа түүхэн туршлага, социалист байгуулалтын ололт амжилттай танилцан үзсэн юм. БНМАУ-д хөгжлийн капиталист шатыг алгасан социализм байгуулсан түүхэн туршлага өнөөгийн үед Ази, Африкийн орнуудын хувьд олон улсын ач холбогдолтойг тэмдэглэн нөхөр Бабрак Кармаль хэлэхдээ: «Энэ туршлага нь шинжлэх ухааны социализмын үзэл санааны үнэний шалгуур, хөгжлийн капиталист шат, үгээгүй хоосон байдал, гачаал зовлонгийн шатыг алгасан, феодализм болон феодализмын өмнөх харилцаанаас социализмд шууд шилжихийн үлгэр дууриал болж³, үндэсний хөгжлийг шийдвэрлэх болон хөдөө аж ахуй, аж үйлдвэр зэрэг салбарт хуримтлуулсан монгол улсын баялаг туршлагыг бид өөрийн оронд шинэ нийгэм байгуулах явцад байнга өсч хэрэглэж байна»⁴ гэсэн юм.

Эрх чөлөө, тусгаар тогтнол зол жаргалант ирээдүйн төлөө афганы ард түмний шудрага тэмцэлтэй манай ард түмэн хувьсгалт эв санааны бат нэгдэлтэй байдаг юм. МАХН, БНМАУ-ын засгийн газар АААН, БНААфГУ-ын засгийн газраас дотоодод явуулж байгаа нийгэм-эдийн засгийн гүнзгий ардчилсан өөрчлөлт хийгээд олон улсын тавцан дээр явуулж буй эсхийг эрхэмлэгч, энх тайвнаар зэрэгцэн орших, эвсэлд үл нэгдэх бодлогыг БНМАУ өндрөөр үнэлдэг билээ. Афганистанд хэрэгжиж буй хувьсгалт өөрчлөлтийг таслан зогсоохыг оролдож буй олон улсын империализм, жанжлах хүчний талынхны дайсагнасан явууллагыг БНМАУ-ын засгийн газар, монголын ард түмэн шийдвэртэй зэмлэн буруушаахын зэрэгцээгээр хоёр орны хоорондын найрамдал хамтын ажиллагааны харилцааг гүнзгийрүүлэх хэтийн төлөв нээгдэж МАХН, АААН-ын хоорондын ах дүүгийн хэлхээ холбоог монгол, афганы ард түмний эрх ашгийн үүднээс цаашид хэлбэрэлтгүй өргөтгөх чиг шугам баримтлахаа Монгол, Афганистаны хамтарсан мэдэгдэлд цохон заасныг энд онцлон тэмдэглэх хэрэгтэй юм.

БНМАУ, БНААфГУ-ын хоорондын Найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээний үзэл санаа, зорилго нь Ази болон даян дэлхийн энх тайван, аюулгүй байдал, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх эрх ашигт нэгэн адил нийцэж байгаа билээ. Гэрээнд зааснаар хоёр улс нийгмийн өөр өөр байгуулал бухий улс гүрнүүд энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг тууштай хэрэгжүүлэх, олон улсын энх тайван, аюулгүй сайдлыг бэхжүүлэхийн тулд хүчин чармайлт тавьж, олон улсын түгшүүртэй байдлыг намжаах явцыг гүнзгийрүүлэхэд тус дөхөм үзүүлэх юм.⁵ Энэ нь БНМАУ, БНААфГУ-ын хоорондын Найрамдал, хамтын ажиллагааны гэрээ нь хоёр орны найрамдалт харилцааг хөгжүүлэхэд төдийгүй улс түмний харилцан ойлгох, итгэлцэх, хамтран ажиллах үйл хэрэгт онцгой чухал ач холбогдолтой юм. Хоёр орны харилцааг бүх талаар бэхжүүлэх нэгдмэл хүсэлтэйгээ илэрхийлэхийн сацуу олон улсын тулгамдсан асуудлаар нийтлэг үзэл бодол, байр сууриа тусган илэрхийлсэн Монгол—афганистаны хамтарсан мэдэгдэл нь дэлхий дахины энх тайван аюулгүй байдлыг сахин хамгаалахад БНМАУ, БНААфГУ хүчин чармайлтаа чиглүүлж байгааг нотлон харуулж байна. Империализмын харгис хүчний үйл ажиллагааны улмаас олон улсын

²«Үнэн» 1983. 7 8.

³«Үнэн» 1983. 7 13.

⁴«Үнэн» 1983. 7. 9.

⁵«Үнэн» 1983. 7. 15.

байдал ноцтой хурцдаж байгаа өнөө үед дайны аюулыг арилгах-зэвсэг хураах, юуны түрүүнд цөмийн зэвсэг хураах салбарт арга хэмжээ авахаас эрхэм зорилт байхгүй гэдгийг БНМАУ, БНААфГУ-ын хамтарсан мэдэгдэлд илэрхийлэв.⁶ Үүнтэй холбогдуулан ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад орны энх тайванч бодлого, чиглэсэн зорилго бүхий үйл ажиллагааг нь улс түмний энх тайван, үндэсний тусгаар тогтнол, нийгмийн дэвшлийн үйл хэргийг хамгаалахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байгааг Монгол—афганистаны хамтарсан мэдэгдэлд онцлон заасан билээ.

БНМАУ, БНААфГУ хоёулаа Ази тивийн орны хувьд тус тивийн байдлыг онцгой анхаардаг. Учир нь америкийн засаг захиргаа, Ази тивийг «амин чухал эрх ашгийн бүс» гэж зарлан, энэ тивийг цөмийн дайны талбар болгон хувиргах ажил явууллага хийж, Японд милитаризм сэргэж байгаа зэрэг нь Ази тивийн аюулгүй байдлыг хамгаалахад тус тивийн улс түмний хүч чармайлтыг нэгтгэхийг шаардаж байна. Үүнд: Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай Конвенц байгуулах БНМАУ-ын санал энхийг эрхэмлэгч бүх орон, энх тайванч хүчний талархлыг хүлээж байгаа билээ. БНААфГУ нь Ази тивийн орны хувьд уг саналын ач холбогдлыг өндөр үнэлсэн байгаа юм. Тэрчилэн Монгол—афганистаны хамтарсан мэдэгдэлд олон улсын бусад олон чухал асуудлаар хоёр улсын баримталж буй бодлого нийлж байгааг тодорхой тусгасан юм. БНМАУ, БНААфГУ-ын олон улсын асуудлын талаархи нийтлэг байр суурь нь «Зөвлөлт Холбоот Улс, ах дүү социалист бусад оронтой тогтоосон нийтлэг найрамдал, ах дүүгийн харилцааг бат бэх гагнан бэхжүүлэх үзэл санааны онцгой тод илрэл болсон юм»⁷

Өөрөөр хэлбэл БНМАУ, БНААфГУ-ын хоорондын ах дүүгийн найрамдал хамтын ажиллагаа нь манай хоёр орны ард түмний язгуур эрх ашигт нийцэх төдийгүй дэлхий дахины энх тайван, аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Монгол—афганистаны харилцаа цаашид гүнзгийрэн хөгжих хөгжлийн шинэ үе шатандаа орлоо. БНМАУ, БНААфГУ-ын хоорондын Найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээний үзэл санаа, заалтын дагуу АААН, БНААфГУ-тай бүх талын харилцаа, хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэх арга хэмжээг төлөвлөн боловсруулж, хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагуудад МАХН-ын Төв Хороо үүрэг болгосон юм. 1983 оны 7-р сарын 19-нд хуралдсан МАХН-ын Төв Хорооны VI бүгд хурал дээр МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю. Цэдэнбал хэлсэн үгэндээ: «БНМАУ, БНААфГУ-ын хооронд найрамдал, хамтын ажиллагаа, дайчин эв санааны нэгдлийн харилцаа амжилттай хөгжиж байгаад сэтгэл гүнээ ханамжтай байгаагаа илэрхийлэхийг хүсч байна. Афганистаны Ардын Ардчилсан Намын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга нөхөр Б. Кармаль тэргүүтэй Афганистаны Нам, төрийн төлөөлөгчдийн саяхан манай оронд хийсэн албан ёсны найрсаг айлчлалын дүн энэ харилцаанд шинэ түлхэц өгөх нь дамжиггүй»⁸ гэсэн билээ.

1983 оны 8-р сарын 19-нд болсон АААН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны хуралдаан дээр Афганистаны нам, төрийн төлөөлөгчдийн БНМАУ-д хийсэн албан ёсны найрсаг айлчлалын дүнгийн тухай АААН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНААфГУ-ын Хувьсгалт Зөвлөлийн дарга нөхөр Бабрак Кармалийн илтгэлийг хэлэлцжээ.

⁶«Үнэн» 1983. 7. 13.

⁷«Үнэн» 1983. 7. 13.

⁸«Үнэн» 1983. 8. 21.

АААН-ын Улс Төрийн Товчоо энэ айлчлалын дүн, хоёр орны төлөөлөгчдийн хооронд хийгдсэн хэлэлцээ, уулзалт ярианы үр дүнг санал нэгтэй сайшаагаад, БНААфГУ, БНМАУ-ын хоорондын найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээ, айлчлалын явцад гарын үсэг зурсан бусад баримт бичгийг өндөр үнэлсэн байна.

«Афганистаны нам, төрийн төлөөлөгчдийг халуун дотно, чин сэтгэлийн байдалд хүндлэн зочилж, Дөрөвдүгээр сарын хувьсгал, түүний хөгжлийн шинэ үе шат, АААН, БНААфГУ-ын засгийн газар ард түмний тэмцлийг зүйл бүрээр гүнээ дэмжиж байгаа МАХН, монголын засгийн газар, ард түмэнд АААН-ын Төв Хорооны Улс төрийн Товчоо талархал илэрхийллээ»⁹ гэж Бахтар агентлаг уламжилсан юм. Ийнхүү манай хоёр нам, улсын ах дүүгийн хамтын ажиллагаа өдөр ирэх тутам арвижин баяжиж, тус хоёр орны найрамдлын түүх улам зузаарч байна.

НОВЫЙ ЭТАП В РАЗВИТИИ МОНГОЛО-АФГАНСКИХ ОТНОШЕНИЙ

(Р е з ю м е)

Апрельская революция 1978 года открыла качественно новые, широкие возможности развития афганского общества по пути социального прогресса и положила начало широким демократическим преобразованиям и тесному сотрудничеству с социалистическими странами, которое стало залогом успешного решения общественно-экономических задач, стоящих перед страной и её главной организаторской силой— Народной Демократической партией Афганистана.

МНР всесторонне поддерживает борьбу молодых, развивающихся стран за национальную независимость и социальный прогресс и, сразу же после победы революции в Афганистане, выразила готовность установить и развивать с ним дружественные связи и сотрудничество в интересах мира и социального прогресса. Эти отношения обогатились новым содержанием и обрели более совершенные формы особенно в период II—этапа апрельской революции.

Развитие многосторонних связей между МНР и Афганистаном за прошедшие 5 лет, стало прочной основой дальнейшего укрепления сотрудничества и братских связей между нашими народами.

Наиболее наглядным примером этого явился состоявшийся в июле этого года официальный, дружественный визит в нашу страну Генерального секретаря ЦК НДПА, Председателя Революционного Совета Афганистана Бабрака Кармаля. Подписанный в ходе визита Договор о дружбе и сотрудничестве между МНР и ДРА является программным документом исторического значения в развитии двустороннего сотрудничества и открыл новый этап в отношениях между нашими странами.

Выступая на VI Пленуме ЦК МНРП, Генеральный секретарь ЦК МНРП тов. Ю. Цеденбал сказал: «Мне хотелось бы выразить глубокое

⁹ «Үнэн» 1983. 8. 21.

удовлетворение по поводу того, что между МНР и ДРА успешно развиваются отношения дружбы, сотрудничества и боевой солидарности.

Итоги завершившегося на днях официального дружественного визита делегации ДРА во главе с Генеральным секретарем ЦК НДПА, Председателем Революционного Совета ДРА товарищем Б. Кармалем в нашу страну, несомненно, придадут новый импульс этим отношениям».

Изучение и анализ опыта некапиталистического пути развития Монголии, отдельных его сторон, сыграет определенную роль в процессе осуществления революционно-демократических преобразований в Афганистане—подчеркивается в статье.

Установление тесных многосторонних связей между МНР и ДРА отвечает коренным интересам наших народов и будет способствовать лучшему взаимопониманию между нашими народами, объединению усилий в борьбе за мир и безопасность в Азии.